



ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ

2023 ОНЫ II УЛИРЛЫН ТҮҮВЭР
СУДАЛГААНЫ ТАЙЛАН


Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн эдийн засгийн төлөв байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.

1. ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ

Инфляцын талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг 2023 оны 6 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 30-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд нийт 1,014 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг хийж гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа.

- Иргэдийн өгсөн хариултаар инфляцын түвшнийг (хүлээлт) тооцвол:
 - 2023 оны III улирлын эцэст I) чанарын хариултаар **11.6%**, II) тоон хариултаар **10.6%**, III) мэдрэмжид суурилсан аргачлалаар **13.3%**;
 - 2024 оны II улирлын эцэст I) чанарын хариултаар **9.0%**; II) тоон хариултаар **10.6%**; III) мэдрэмжид суурилсан аргачлалаар **7.7%** байхаар байна.
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 24% нь 2024 оны II улиралд инфляцын түвшинг зорилтот түвшнээс хэтрэхгүй гэсэн хүлээлттэй байна.
- Иргэдийн 95% нь өнгөрсөн 3 сард үнэ өссөн, 72% нь ирэх 3 сард үнэ өснө гэж хариуллаа.
- Эдийн засгийн өсөлтийн талаарх иргэдийн хүлээлтийн утга өмнөх улирлаас нэмэгдэж, “өснө” гэсэн мужид хэвээр хадгалагдлаа.
- Ханшийн чиглэлийн индексийн утга “төгрөг суларна” гэсэн мужид хэвээр хадгалагдсан хэдий ч төгрөгийн ханш суларна гэсэн хандлага буурсан хэвээр байна.
- 2020 оны эцсээс судалгаанд оролцогчдын ихэнх нь өрхийн санхүүгийн байдал ирэх 3 сард муудна гэсэн хариултыг өгч байсан бол энэ улирлын судалгаагаар иргэдийн хүлээлт сайжирч, өрхийн орлого “сайжирна” гэсэн муж руу шилжлээ.

Иргэдийн инфляцын хүлээлт



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

2. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Иргэдийн өгсөн хариултаар 2023 оны III улирлын инфляцын хүлээлтийг тооцоход тоон хариултын хувьд 10.6%, чанарын¹ хариултаар 11.6%, мэдрэмжид суурилсан /perceived inflation/² аргачлалаар 13.3%-тай байхаар гарсан байна /Зураг 2.1/.

Харин 2024 оны II улиралд (1 жилийн дараа) инфляцын хүлээлтийн утга тоон хариултаар 10.6%, чанарын хариултын хувьд 9.0%, өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан аргачлалаар 7.7%-тай байхаар байна /Зураг 2.2/.

Иргэдээс ирэх 3 сард үнийн өсөлт ямар байх талаар төсөөллийг асууж, чиглэлийн индекс³-ийг тодорхойлоход “инфляц хэвэндээ байна” гэсэн мужид хэвэндээ байна. Үүнийг өмнөх улиралтай харьцуулахад үнэ өснө гэсэн иргэдийн хандлага нэмэгдсэн байна /Зураг 2.3/.

Инфляцын хүлээлтийн чанарын хариултын хувьд иргэдийн 72% нь ирэх 3 сард үнийн түвшин өснө гэж үзсэн. Тухайлбал өмнөх улиралд 32% нь үнийн түвшин одоогийн түвшнээс илүү хурдацтайгаар өснө гэж хариулж байсан бол энэ удаагийн судалгаагаар 41% болж нэмэгджээ. Мөн 22% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй, 9% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурд буурна гэж хариулжээ /Зураг 2.4/.

Зураг 2.1 | Иргэдийн инфляцын хүлээлт /ирэх 3 сар/



¹ Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцсон.

² Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцын хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажил


Зураг 2.2 | Иргэдийн инфляцын хүлээлт /ирэх 12 сар/



Зураг 2.3 | Үнийн өсөлтийн талаарх хандлага /чиглэлийн индекс, ирэх 3 сар/



Зураг 2.4 | Ирэх 3 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?




³ Өснө, буурна гэсэн хариултаудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ иргэдээс ирэх 12 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултаудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.


Иргэдийн инфляцын хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляц ирэх 3 сард буюу 2023 оны III улиралд 10.6%, 12 сарын дараа буюу 2024 оны II улиралд 10.6% байхаар хүлээгдэж байна /*Зураг 2.5*/.

Инфляцын хүлээлтийн тоон хариултын хуримтлагдсан тархалтаас харахад 2023 оны III улиралд иргэдийн 24%, 2024 оны II улиралд иргэдийн 24% нь инфляцын хүлээлтийн утга зорилтот түвшин болох 6%-иас хэтрэхгүй байна гэж хариулсан /*Зураг 2.6*/.

Зураг 2.5 | Иргэдийн инфляцын хүлээлтийн тархалт /тоон хариултаар/



Зураг 2.6 | Иргэдийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

3. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТЭД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛ


Макро эдийн засгийн хүчин зүйл

Эдийн засгийн өсөлт⁴: Энэ оны эхний хагас жилд манай улсын экспорт 7.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2.3 тэрбум ам.доллар буюу 43%-иар өслөө. Энэхүү өсөлтөд нүүрсний экспорт 2.0 тэрбум ам.доллаароор өссөн нь голлон нөлөөлөв. Түүнчлэн уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 3.7 их наяд төгрөг буюу 67.3%-иар өсжээ. Үүнтэй уялдан иргэдийн эдийн засгийн нөхцөл байдалд өгөх үнэлгээ нэмэгдсээр байна. Тухайлбал энэ удаагийн судалгааны үр дүнгээр иргэдийн 45% нь ирэх 3 сард “эдийн засаг өснө” гэж үзэж байгаа бол 31% нь хэвэндээ байна гэжээ /*Зураг 3.1*/.


Валютын ханшийн хүлээлт⁵: Төгрөгийн ам.доллартой харьцах 2023 оны 6-р сарын дундаж ханш 3,438.26 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар суларсан байна. Валютын ханшийн хүлээлтийн чиглэлийн индекс өмнөх улиралд “төгрөг суларна” гэсэн мужид байсан бөгөөд энэ улиралд ч мөн тус мужид хэвээр хадгалагдлаа /*Зураг 3.2*/.

Зээлийн хүүний хандлага⁶: Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2023 оны 6 сарын эцсийн байдлаар 16.3%-тай байна. Зээлийн хүүний талаарх иргэдийн хүлээлтийг авч үзэхэд ирэх 3 сард зээлийн хүү одоогийн түвшинд хадгалагдана гэж иргэдийн 54% нь үзэж байгаа бол 19% нь өснө, 16% нь буурна гэжээ. Зээлийн хүүний чиглэлийн индекс 2022 оны I улирлаас хойш “өснө” гэсэн мужид хэвээр байгаа хэдий ч энэ улиралд тус үзүүлэлт бага зэрэг буурлаа /*Зураг 3.3*/.

Зураг 3.1 | Эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Зураг 3.2 | Валютын ханшийн талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Зураг 3.3 | Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

⁴ Бюллетень, www.statmongolbank.mn
Гадаад худалдааны VI сарын тойм, www.statmongolbank.mn
⁵ Бюллетень, www.statmongolbank.mn

⁶ Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээл оруулснаар)

Микро эдийн засгийн хүчин зүйл

Өрхийн орлогын хандлага:⁷ 2020 оны IV улирлаас эхлэн өрхийн бодит орлого буурсантай холбоотойгоор иргэдийн хүлээлтийн утга өрхийн орлого “муудна” гэсэн мужид хадгалагдаж байсан бол энэ улирлын судалгааны үр дүнгээр иргэдийн хүлээлт сайжирч, өрхийн орлого “сайжирна” гэсэн муж руу шилжлээ /*Зураг 3.4*/. Тухайлбал өмнөх улирлын судалгаанд хамрагдсан иргэдийн 10% нь ирэх улиралд өрхийн орлого нэмэгдэнэ гэж хариулж байсан бол энэ удаагийн судалгаанд оролцсон иргэдийн **24% нь ирэх 3 сард өснө, 56% нь өөрчлөгдөхгүй**, харин 18% нь буурна гэж хариулжээ.

Өрхийн орлого ирэх 3 сард өснө гэж хариулсан иргэдээс шалтгааныг тодруулахад 42% нь тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө өснө, 35% нь цалин өснө, 9% нь бизнесийн орлого өснө, 7% нь давхар ажил эрхэлнэ, 3% нь бусад орлого өснө 2% нь бараа, бүтээгдэхүүний үнэ буурна гэж хариулжээ /*Зураг 3.5*/.

Өрхийн хэрэглээний хандлага:⁸ 2021 оны III улирлаас эхлэн иргэдийн хүлээлтийн утга өрхийн хэрэглээ “өснө” гэсэн мужид тогтмол хадгалагдсаар байна /*Зураг 3.6*/. Энэ удаагийн судалгаанд оролцогчдын 43% нь өрхийн хэрэглээ ирэх 3 сард нэмэгдэнэ гэсэн бол 38% нь өөрчлөгдөхгүй, 18% нь буурна гэж хариулжээ.

Зураг 3.4 | Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт, өрхийн орлого /ирэх 3 сард/



Зураг 3.5 | Өрхийн орлого өсөх шалтгаан



Зураг 3.6 | Өрхийн хэрэглээний талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

⁷ Нэрлэсэн цалингийн индексийг 2015 оны сууриар тооцож бодит цалингийн индекст шилжүүлсэн үзүүлэлтийг харьцуулав. ӨНЭЗС, www.1212.mn

⁸ Өрхийн сарын дундаж бодит мөнгөн зарлагын жилийн өөрчлөлтийг тооцож харьцуулав. ӨНЭЗС, www.1212.mn


Зээлийн хэрэгцээ үүсэх эсэх: Шинээр олгосон зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49%-иар өссөн байна. Өрхийн зээлийн хэрэгцээний чиглэлийн индексийн тооцоход 2022 оны IV улирлаас хойш “өснө” гэсэн мужид хадгалагдаж байна. Тухайлбал судалгаанд оролцогчдоос ирэх 3 сард нэмэлтээр болон шинээр зээлийн хэрэгцээ үүсэх эсэх талаар асуухад 58% нь зээлийн хэрэгцээ үүснэ, үлдсэн 42% нь зээлийн хэрэгцээ үүсэхгүй гэж хариулжээ /*Зураг 3.7*/.

Зураг 3.7 | Өрхийн зээлийн хэрэгцээ /ирэх 3 сард/




Хадгаламжийн хандлага⁹: Иргэдийн хадгаламжийн талаарх чиглэлийн индекс өмнөх улиралд “буурна” гэсэн хүлээлттэй байсан бол энэ улиралд мөн тус мужид хэвээр хадгалагдлаа /*Зураг 3.8*/. Судалгаанд оролцогчдын 56% нь хадгаламж эзэмшдэг бөгөөд ирэх 3 сард 25% нь хадгаламжаа бууруулах буюу хадгаламжаасаа хэрэглээнд зарцуулахаар төлөвлөж байна. Харин 55% нь хэвээр нь хадгалж, 20% нь хадгаламжаа нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Зураг 3.8 | Өрхийн хадгаламжийн талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Өнөөгийн эдийн засгийн нөхцөлд удаан эдэлгээтэй бараа худалдаж авахад тохиромжтой эсэхийг асуухад иргэдийн 39% нь тохиромжгүй, 23% нь тохиромжтой гэж хариулсан байна /*Зураг 3.9*/.

Зураг 3.9 Өнөөгийн эдийн засгийн нөхцөлд удаан эдэлгээтэй бараа худалдаж авахад тохиромжтой эсэх



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

⁹ Иргэдийн төгрөгийн хадгаламжийн өөрчлөлтийг тооцож харьцуулав. Бюллетень, www.statmongolbank.mn